

**ХУБИЛАЙ ХААН БА МОНГОЛ ГҮРНЭЭС АЗИ НОМХОН ДАЛАЙН  
БҮС НУТАГТ ЯВУУЛСАН ЦЭРЭГ, УЛС ТӨРИЙН БОДЛОГЫН  
ЗАРИМ АСУУДАЛ**

Д.Галбаатар доктор, профессор

МУИС, МХСС, Утга зохиолын тэнхим

Монголын их эзэнт гүрний үеийн байлдан дагуулалт, цэрэг дайны үйл ажиллагаа, дэлхийг донсолгосон агуу их ялалтуудын дотор байдаг нэгэн гунигтай атлаа бүдэг түүх бол их далайн хээлэнд агчид орших Наран улсад явуулсан цэргийн үйл ажиллагаа юм. Энэ нь Төв Азийн эрс тэс уур амьсгалтай тэгш хээр талын энгээр дураараа нүүдэллэн амьдрагч, 4 зүг найман зовхицт дэлхийн хуурай газрын дийлэнх талыг өөрийн эрхшээл ноёрхолдоо нэгэнт оруулаад асан Монголчуудын хувьд төмөр дөрөө мултлан бууж, хязгаар хярхаггүй их далайд хөвөн тулалдах шийдэлд хүрсэн нь гайхалтай, ихээхэн ухаан, зориг хүч шаардсан монгол цэргийн урлагт урьд тохиолдоогүй асар том аз туршсан алхам байв.

Эл довтолгооны түүхийн бүдэг зөргөөр мөрдөн мөшгих явцад сонирхолтой мэдээ занги цөөнгүй таарч байна. Ялангуяа цэрэг- улс төр, дипломатын уян хатан бодлого, Японы арлууд руу довтлох болсон шалтгаан, олон улсын цэргийн хамтын үйл ажиллагааны талаар цуглуулсан зүйлсээ уншигчидтай хуваалцах нь холоос ирсэн хүнээс үг сонсох дуртай манай уншигчдад сонин байж мэдэх юм.

### Япон улс дахь түүхт газрууд

Их Юань гүрний цэргийн довтолгооны үеийн түүх, олдворыг цуглуулсан Юаны цэргийн түүхийн музей Японы 4 том арлын нэг Кюшу арлын Фукоако мужийн Фукоака хотын Хаката дүүргийн Хигаши хэмээх цэцэрлэгт хүрээлэнд буй. Энэ музейг 300 иенээр үздэг аж. Музей байгаа газарт анх Юан /монгол/ цэрэг хөл тавьж, тулалджээ. Далайн хөвөөний бяцхан довцогт байрлах эл газрын ойролцоо Монгол цэрэг очиходоос 10 гаруй жилийн Ничирэн хэмээх нэгэн лам амьдрал суудаг байж. Тэр бурхан шашны номд нэвтэрхий төдийгүй ирээдүйд болох явдлыг урьдчилан мэддэг увидаст үзмэрч байсан гэж Япончууд домоглон ярыцаана. Шашны бэлгэ тэмдэг жанч нөмөрсөн энэ ламтны босоо хөшөө музейн дэргэд сундэрлэнэ. Тэрээр Монголчуудын довтолгооноос даруй 14 жилийн өмнө буюу 1260 онд бичсэн номдоо харийн цэрэг энд ирж их дайн дажин болно гэж бичжээ. Тэр нь Юан цэргийн довтолгоо байсан гэдэг.

Уг музейд XIII зууны үеийн Японы аж амьдрал, цэрэг, хамгаалалтын тухай түүхэн явдлын сэдэвт уран зураг /эдгээрт үндэснийхээ дүрэмт хувцастай, үсээ самурайн ёсоор сайхан самнаж, илд юугаа барьсан цэвэр цэмцгэр самурай нар ялан дийлж, үс сахалдаа баригдсан Юан цэрэг дийлдэж, аллага, хучирхийлэл үйлдэж байгааг харуулсан нь ОХУ-ын Владимир хотод байх Татар-Монголын довтолгооныг зогсоож байгаа Орос цэргийн сүр хүчийг бахархалтайяа үзүүлсэн Алтан сүмийн доторх панорамтай агуулгын хувьд яг ижил байсан нь сонирхолтой байлаа/, 1260 оноос хойш эрэг хавийн хуурай газар болон далайн ёроолоос олдсон Юан болон Япон цэргийн жанждын хөрөг, байлдааны газрын зураг, зэр зэвсэг, эд үлгийн зүйлс, хувцас хэрэглэл, Юан ба Япон цэргийн хооронд хийсэн далай дээрх болон хуурай газарт болсон тулалдааны үйл явцыг харуулсан зураг, шарын шашны

холбогдолтой эд зүйлс байхын хамт Аину /хойд их арал Хоккайдад амьдардаг/ үндэстний түүхийн үзмэр байна. Үүнээс сонирхолтой нь Юан цэргийн жанжин мөнгөн тооног дуулга, өвөрмөц технологоор хийсэн тоосго, чулуун аяга, монгол цэргийн гоёмсог шигтгээтэй морин жад, Нансо /Хятад/ цэргийн даринь бортого./бортогыг Нагасаки мужийн Такашимагийн ойролцоо далайгаас олжээ./ Өөр нэг сонирхолтой үзмэр бол Хубилай хааны эзэнт гүрний цэргийн дээд тушаалын жанжин нар хэрэглэж байсан гэх Зэс тамга юм. Түүнийг Хубилай хаан Юан цэргийн дээд, дунд тушаалтуудад хэрэглүүлэхээр зарлигаар тогтоож байж.

1269 онд Хубилай хаан Пагва ламаар Төвд үсэгт тулгуурласан дөрвөлжин үсэг зохиолгож Юан улсын бичиг гэж зарласан ба зүүн гар талаас эхлэн босоо бичдэг энэ үсгийг өөрийн захиргаанд байдаг бүх үндэстний хэлээр бичиж болохуйц үсэг болгохыг зорьж байжээ. Энэ тамганы дардас талд уг жанжин, тушаалтын алба хэргэм, нэрийг сийлж, ар талд нь олгосон огноог /Хубилай хааны 14-р он буюу 1277 он/ бичжээ. Энэ олдворын талаар судлагчид санал зөрүүтэй байдаг аж. Зарим судлаачид Юаны Хятад цэргийн дунд тушаалын даргын тамга гэж үздэг юм байна. Тамга дээрх dzundyin, gongeun гэдэг үсгийг 100-500 хүртэлх цэрэг захирдаг хүний тамга гэж тайлжээ. Тамганы хэмжээ: бариулын өндөр 4,4 см, зузаан 1,2-1,4 см, өргөн 3,1-3,4 см, тамганы өндөр, өргөн тус тус 6,5 см, дарах хэсгийн эх биеийн зузаан 1,5 см, нийт жин нь 726 гр аж.

Өөр нэг дурсгалт газар бол 1275 онд Хубилай хааны зараалаар очсон 5 элчийг удтал саатуулж, дараа нь цаазалсан газарт булш дээр нь босгосон чулуун гэрэлт хөшөө юм. Энэ булш Токиогоос холгүй Сагами хотын ойролцоо Тацуноокучи гэдэг газарт буй /Энэ тухай хойөө өгүүлнэ/. Япон улсад илгээсэн Хубилай сэцэн хааны 1 хувь захидал Осака хотын ойролцоо Тодажи сүмд хадгалагдан буй. Түүний хуулбар, орчуулгыг Япон улсад хийсэн УИХ-ын даргын айлчлалын үеээр бэлэглэсэн нь үнэт чухаг түүхийн дурсгал юм. Үүнээс гадна Тусачу тэргүүтэй цаазлагдсан 5 элчийн гэргийдээ зориулсан 4 мөр шүлгийг чулуун дээр сийлсэн дурсгал байдгийг үзэж чадаагүй билээ. Өнөөдөр Японд их Чингис хааны нэртэй, монголчуутдтай холбоотой хоол унд, ууш зууш, аялал жуулчлал, амралтын газар олширч буй боловч Хубилай хааны нэртэй зүйл тэр бүр үзэгдэггүй нь бас нэг сонин үзэгдэл юм.

### Хубилай хааны дипломат бодлого ба түүний элчис

Хувилай хаан их далайн гүнд нууцлаг аж төрж суудаг Япон орныг эзлэн авч боол зардасаа болгох, алт эрдэнэсийг нь хуурайлан хамах санаа өвөрлөж байгаагүй бололтой. Харин дэлхий дахиныг нэгэн жолоо захиргаа, дээвэр дор хураах гэсэн үе үеийн монголын их хаадын улс төр- цэргийн бодлогын үргэлжлэл, тэхдээ эцэг дээдсийн дипломатын уран арга, эв зэийг тууштай баримталж байсныг 1274 оны анхдугаар довтолгоо төдийгүй 1281 оны хоёр дахь довтолгооны өмнө явуулж байсан улс төрийн дипломат үйл ажиллагаа, элч нарын хичээл зүтгэл гэрчилдэг юм. 1266-1281 оныг хүртэл урт удаан хугацаанд үргэлжилсэн, олон удаагийн элч нараар далай гатлуулан дамжуулсан энэ дипломатын оролдлого нь эцсийн дундээ түүнийг ялагдалд хүргээ юу даа гэх харамсал төрүүлдэг. Энэ бүх хугацаанд Японы цэрэг шаардлагатай бүх арга хэмжээг авч хаалт далан, бэхлэлтээ зузаалан цэргийн хүчээ бэхжүүлж байжээ. 1274 оны тактикийн чанартай анхны довтолгооны дараа Япончууд Хаката буланг тойруулан өндөрөөрөө 2,5 м, уртаараа 20 км урт ханан хэрэм босгожээ.

Хубилай хаан анх 1266 онд Коктеки, Инкоу хэмээх хоёр элчид захидал /тулган шаардах бичиг/ бариулан Япон улс руу илгээсэн ба уг захидал ерөнхийдөө

Та бүхэн Юань улсын захиргаан дор нэгдэгтүн гэсэн утгатай ба хэрэв Япон улс бидний саналыг эс хүлээвээс цэрэг зэвсэгийн хүч хэрэглэнэ гэсэн өнгө аяс нэвтэрхий байсан тул Японы тал энэ захидалыг таагүй хүлээж авчээ. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйл бол гадаадын түрэмгийлэл үзээгүй, хаагдмал Япон үндэстний олон улсын хооронд баримталж асан харилцан хүндэтгэх, ойлголцох ёс заншилд харш зүйл байсан гэж япон түүхчид тайлбарладаг. Тиймээс хариу өгөлгүй элч нарыг буцаажээ.

1267 оны сүүлээр Ханбу хэмээх солонгос элч хоёр янзын захидал авч Япон руу явсан бөгөөд тэр 1268 оны эхээр Хаката аралд хүрчээ. Хоёр захидалын нэг нь Хувилай хааны, нөгөө нь өөрийнх нь хувиасаа бичсэн сэргэмжлүүлэг захидал байжээ. Энэ үед Солонгос улс нэгэнт Монголын их гүрний эрхшээлд бүрэн ороод байсан үе. Тэд Монголын эзэнт гүрэн, Японы хооронд орших тул Япон улстай найрсаг харилцаатай байжээ. Тэр өөрийн сэргэмжлүүлэх захидалд Юан улс хучирхэг гүрэн тул тэдний саналыг хүлээн авч сайн харилцаа тогтоох нь та нарт ээлтэй. Бид ч гэсэн Монголын Их хаанд Япон улсыг нэгтгэх гээд хэрэггүй гэж гүйн ятгасан ч тэр саналыг хүлээж авсангүй ээ. Монголчууд, та нартаа сайн андын холбоо тогтоож, гэрээ байгуулахыг хүсч байна. Монголчууд дөрвөн далайд буй бүх улс орныг нэгэн жолоонд оруулж их хаан өөрийн нэр сурийг мандуулжээ. Хэрэв танай Япон улс Монголын захиргаанд нэгдвэл тэд та нарыг дуртайяа хүлээн авч найрсаг сайнаар хандах болно. Тиймээс Монголчуудын саналыг хүлээн авах нь дээр... хэмээн зөвлөн ятгасан аж.

Хубилай хааны захидал ч дээрх захидалын агуулгатай төсөөтэй байв. Япон улсын Багкуху /Засгийн газрын Цэргийн зөвлөл/ түүний дээр Чутейн /эзэн хаан/ засаглалтай байв. Эл захидал ирсний дараа Улс төрийн хэргийг эрхлэх Засгийн газар буюу Цэргийн зөвлөл /Багкуху/ захидалын асуудлыг дангаар шийдэх эрх хэмжээ хүрэхгүй учраас Чутей буюу Эзэн хаанд толилуулжээ. Гэвч Засгийн газар ч, эзэн хаан ч цөмөөр айн мэгдэж цэрэг зэвсгээ бэлтгэхээсээ илүү Хаан сүмд залбиран мөргөж, улмаар Багкуху буюу Цэргийн зөвлөлд очиж Монголчуудаас авран хамгаалаач гэж гүйцгаажээ. Цэргийн эрхтнүүд хариу захидалдаа Монгол улсын хааны захидал ёс журамгүй, таатай бус хэмээгээд элчийн захидалыг хүлээж авахгүй гэдгээ мэдэгдэхээр шийдсэн боловч ямар нэг шалтгааны улмаас илгээсэнгүй. Энэ үед Эзэн хаан сүмд очин хамгаалалтын тортон цэргээр бэхлэн ажин түжин суух болсон байна. Энэ зуур элчин Хамбу бүтэн 5 сар хүлээгээд дараа нь хариу өгөхгүй гэдэг уг сонссон байна. Ийнхүү элч Хубилай хаанд очиж ажил хэрэг бүтээмж муутай явснаа мэдэгдэн их хаанаас өршөөл эржээ.

Хубилай хаан зорилгоосоо няцсангүй. 1268 оны 12 сард Коктеки, Инкоу хэмээх монгол хэлтэй анх илгээсэн хоёр солонгос элчийг дахин томилж, олон дагуулын хамтаар Японд илгээжээ. Эдний бүрэлдэхүүнд Шинши Сэн, Чинши Ку /солонгос/ мөн 8 монгол, 4 солонгос төлөөлөгч, 70 дагуулын хамт оржээ. Тэд Японы Цушима аралд очоод Яагаад Их хааны илгээлтэд хариу эс өгсөн учрыг лавлахын зэрэгцээ Цушима арлын ард иргэдтэй тар тур хийж, 1269 он гартал тэнд байгаад хариу авч чадаагүй тул Цушимагийн 2 хүнийг барьцаалан буцсан байна. Ингээд 7 сард 2 монгол элч мөнөөх Цушимагийн хоёр хүнийг дагуулан Солонгосоор дамжин Их хааны ордноо хүрчээ. Гэтэл Хубилай хаан тэдгээр барьцааны хүмүүсийг найрсагаар хүлээн авч зочлохын зэрэгцээ Япон орны тухай дэлгэрэнгүй асуун сонирхоод тэдгээр хүмүүсийг буцааж өгөх далимаар дөрөв дэх элчийг томилсон байна.

Ингээд 1269 онд Урудай хэмээх монгол элч, Кин Юу Се, Ко жу хэмээх хоёр Солонгос элчийн хамтаар Цушимад ирж Их хаан миний захидалын хариуг яагаад өгөхгүй байна гэсэн утгатай захиаг Камакурад байгаа Багкуху /Цэргийн зөвлөл/-д

хүргүүлсэн бөгөөд үүнд Багкуху хариу бичсэн боловч явуулах эсэхээ шийдэж чадахгүй байсаар багагүй цаг авчээ. 1270 оны эхээр бичсэн тэрхүү захидалын утга нь: Манай Япон улсын хувьд Монгол гэж дуулаагүй улс орон билээ. Манай улстай холбоо тогтоохыг хүчээр шахан шаардаад, үгэнд орохгүй бол цэрэг илгээнэ хэмээн айлгах нь бидэнд их таагүй сэтгэл төрүүлж байна. Манай улс дээр үеээс Ками бурхны хамгаалал дор байсаар нэг ч удаа өөр улсын эрхшээл ноёрхолд ороогүй билээ. /энэ нь үнэн бөгөөд Япон улс бүх түүхийнхээ туршид гадаадын цэргийн түрэмгийлэлд хоёрхон удаа өртсөн орон юм. XIII зууны сүүлээр Монголын эзэнт гүрний, XX зууны дундуур Америкийн цэргийн довтолгоонд өртсөн аж/ хэмээн бичжээ. Гэвч ард иргэд нь харь холын хүчирхэг Хаанд таагүй сэтгэгдэл төрүүлж болохуйц ихэмсэг тоомжиргүй үтгэй эл захидалыг илгээхээс татгалзсан тул Цэргийн зөвлөл улс төрийн агуулгатай албан ёсны хариу өгөхөө больсон байна. Хувилай хааны олон удаагийн дипломат оролдлого ийнхүү удаа дараа талаар болсоор байсан ч элч илгээх явдлыг зогсоосонгүй.

1271 онд Их хааны элчээр Чо Лю хицу /хятад хүн/ хэмээх хүн далай туулан Хаката хотын Изаму хэмээх Яаманд хүрч очжээ. Тэр 100 гаруй дагалт, бараа бологдын хамтаар очсон гэдэг. Гол зорилго нь Хубилай хааны захидалын хариуг шаардах явдал байв. Тэрээр хувилсан хоёр хувь эхийг Чутэй /Эзэн хаан/ болон Засгийн газарт дээш хүргүүлж үндсэн эхийг өөртөө авч, хэрэв 11-р сар хүртэл хариу өгөхгүй бол довлоно гэж хатуу анхааруулж, элчин Хамбүгийн нэг адил хувийн сээрэмжлүүлэг захидал бичсэн ч Их хааны ч, Чо Лю хицүгийн ч захидалд хариу өгсөнгүй. Яг энэ үед буюу 1271 оны 11-р сарын 16-нд Монголын эзэнт улс Юань гүрэн болж байгуулагдаад байв. Хятадын газар нутаг дээрх олон улс /Нансо улсаас бусад/, Солонгос бүхэлдээ улмаар Бирма, Камбожи, Вьетнамын зарим нутаг Их Юань гүрний эрхшээлд ороод байв. Энэ зуур ихээхэн цаг хожсон Японы Багкуху буюу Цэргийн зөвлөл Юаны захиргаанд орохгүй гэдэг шийдвэр дээр нэгэнт тогтсон байлаа. Ингээд хариу авч эс чадсан Чо Лю хицу 1272 онд бараа бологдын хамтаар эх газар руу буцжээ. Тэдэнтэй хамт Яширо тэргүүт 12 япон хүн явсан байна. Чо Лю хицу, түүний нарийн бичгийн дарга Чотаку хоёрт нэгэн боломжийн боловч бүтэшгүй санаа байжээ. Тэр нь дээрх 12 япон хүнийг Япон улсын элч хэмээн Их хаан Хувилтай уулзуулаад Япон руу хийх довтолгооныг зогсох санаа байжээ. Харамсалтай нь Их хаан хэргийн нарийн учрыг гадарласан тул тэдгээр элчийг хүлээж аваагүйгээр барагчийг Япон руугаа утэр буцахыг зарлиглажээ.

Ихээхэн туршлага, нарийн ухаантай дипломатич Чо Лю хицу, Чотаку хоёрын санаачлагаар Солонгос элч Кошиш уг 12 япон хүний хамт Солонгосын засаг захиргаанаас бичсэн захидалын хамт элчээр илгээсэн байна. Тэр захидалд Манай улсаас /Солонгос/ хоёр удаа элч илгээж Монголын Их хааны захиаг хүргүүлсэн ч танай улс хариу эс өгч, саналыг хүлээн авсангүй. Тиймээс бид Япон улс руу довтлох болно. Энэ боломжоос хожимдвол юу болохыг төсөөлж байгаа байх... Аймшигт явдал болно гэж анхааруулаад Та нар яаралтай найрсаг харилцаа тогтоох нь зөв зам болно. Ингэвэл манай Солонгос улс Юан, Япон хоёр улсын дунд байж, чадлын хэрээр туслах болно. Үүнийг сайтар бодож тунгаагтун гэж зөвлөсөн байлаа. 1273 онд Чо Лю хицу дахин Японд очжээ. Энэ удаа ч тэрээр зорилгоо мөн л биелүүлж чадаагүй аж. Тэр эргэн ирээд Японд довтлох нь ямар ч ашиггүй нөхцөл байдал бүрэлдээд байгааг Их хаанд тайлбарласан байна.

Гэвч Хубилай хаан 1274 онд Солонгосын далайн цэргийн хөлөг онгоц үйлдвэрлэх газруудад том жижиг нийт 900 хөлөг онгоц угсралт зарлиг буулгажээ. Удалгүй 1275 онд Солонгосын Кин Хо Ке-гээс Хубилай хаанд нэгэн өргөх бичиг илгээж, одоогоор манай Солонгос улсын цэрэг, эдийн засаг маш ядуу, дорийн байгааг харгалзан үзэхийг хүсчээ. Гэвч Хубилай хаан энэ хүсэлтийг сонсохыг

хүсээгүй бөгөөд Монголын Их эзэнт гүрний далайн цэрэг Солонгосын хойгт буун Каппо гэдэг боомт хотод хэсэг хугацаанд хуарагнаж байгаад хөлөг онгоцууд бэлэн болмогц шууд далайд гарчээ. Монголын их гүрний далайд хийсэн анхдугаар довтолгоон ийнхүү эхэлжээ.

1274 оны 10 сарын 20-нд Юань цэрэг Хаката далай дээр үзэгдэж Хакузаки, Хаката арлуудад бууж эхэлжээ. Энэ флотын тэн хагас нь Монгол, Хятад нийлээд 20000, Солонгосын 20000 цэрэг тус тус буусан байна. Гэвч маргааш нь буюу 21-нд гэнэт харагдахаа болжээ. Үүнийг Япончууд Камиказе залгисан гэж домог лугаа хэлэлцэж тэрхүү бурхны салхи ердөө ганцхан хөлөг онгоцоос бусдыг залгисан, тэр хөлгийн ахмад далай руу үсрэн амиа хорлож бусад 50 цэргийг Япончууд олзлон Локухара гэдэг газар руу хүргэж тэнд цаазалсан гэж ярих бөлгөө. Энэ түүх Бөнэйгийн Эки буюу 1274 он бөгөөд Бөнэйгийн хаанчлалын 11 он байсан гэж ном сударт бичжээ. Энэ хэрэг явдлын түүх нэлээд эргэлзээтэй бөгөөд бараг домог үлгэрийн шинжтэй болсныг шинэ түүхчид нэлээд анхааралтай судласаар байгаа аж.

Монголын эзэнт гүрний цэргийн анхны довтолгооны зорилгыг янз бүрээр тайлбарлаж байна. 1. Марко Поло Их хаан Хубилайд зүүн далайн гүнд Zipang /Япон/ хэмээх алт эрдэнэсээр баялаг, баян чинээлэг улс бий гэж хэлсэнээс үүдэлтэй гэж ч үзэх нь бий. Мөн нэг Солонгос хүн тэгж хэлснээс үүдэлтэй ч гэх нь байна. Ийм шалтгаанаар довтолсон гэж үздэг нэг хэсэг судлагчид байна. Энэ ч бас домог үлгэрийн шинжтэй гаргалагаа аж. Эдгээрээс хамгийн үнэнд ойртсон дүгнэлт бол Монголын эзэнт гүрэн хараахан эзлэгдээгүй байсан Нансо улс Япон улстай улс төр, ялангуяа худалдаа эдийн засаг, соёлын салбарт гүн харилцаатай байсан тул Хубилай хааны хувьд Нансог өөрийн харьяанд оруулахад Японы тусламж, хэлхээ холбоог таслах явдал чухал ач холбогдолтой байсан бололтой. Нансо улс ч өөрийн улсыг тусгаар байлгахад Далайн хүчирхэг холбоотон хэрэгтэйг ойлгож байсанаас Япон эзлэгдэх нь Нансогийн хүч супарч доройтохын шалтгаан гарна гэж үзэж бүх талаар холбоогоо зузаатгахыг ил далд оролдсоор байжээ. Харамсалтай нь Монгол цэрэг анх Японд довтолсноос хойш 5 жилийн хойно 1279 онд Монголын эрхшээлд Нансо бүрэн орсон түүхтэй. Үүнээс сонирхолтой дүгнэлт хийж болно. Хажуухандаа байгаа Нансод цохилт өгөхөөс өмнө олон жилийн турш элч илгээн эцэст байлдаж сураагүй далайн дайныг эхлүүлсэн нь Монгол цэргийн урлагт хийсэн туйлын зоримог алхам төдийгүй онц чухал ач холбогдолтой цэрэг дайны уран нарийн тактик, стратегийн чанартай сонголт байжээ. Өөрөөр хэлбэл эхлээд Нансог, дараа нь Жипанг эзлэх нь ээлжит зорилт байж. Гэвч Нансог эзлэхэд далайгаас хүч хавсарч болзошгүй Япон улсыг сүрдүүлж холбоо хэлхээг нь таслан тусгаарлах шаардлагатай байсан гэсэн дүгнэлт нэлээд ултай нь байж мэднэ.

### Бөнэйгийн Ики /1274 оны анхдугаар довтолгоон/-ны үед

Монголын эзэнт гүрний цэрэг Цушимад орж, дараа нь Ики орчим Хаката далайд үзэгдээд, удалгүй гэнэт ор сураггүй болсон гэдэг. Цушима арал эх газартай харьцдаг гол боомт байв. Энэ жижиг арал Нансо, Жипангийн харилцааны гол төв учраас түүнийг дахин сэргэхгүй болгох нь Монголчуудын эх газарт даруй хийх дайны ялалтыг хангах ач холбогдолтой байсан гэж Японы судлагчид тайлбарладаг. Түүгээр ч зогсохгүй Бөнэйгийн Ики-н гол зорилго нь Цушимаг эзлэн номхруулахад чиглэж байсан учраас камиказе/ямар нэг далдын шидэг хүчин бус далайн хар шуурга буюу тайфун бөгөөд хавар намарт үргэлжид дэгдэж далайд яваа хөлөг бүү хэл эх арлууд дээр аймшигт сүйтгэлүүдийг ямагт учруулж байдаг байгалийн догшин үзэгдэл болно-/д залгиулсан бус зорилгоо хэрэгжүүлээд гэнэт алга болсон нь эх

газар руугаа буцсан хэрэг хэмээн тайлбарласан нь ч бий. Үнэхээр 1274 оны Эки-н байлдааны ажиллагааны зураг үүний маш тод нотолгоо болдог.

Ийнхүү Монгол цэрэг үүргээ амжилттай биелүүлээд яаран буцсан нь голтой тайлбар гэж болмоор. Далайн шуурганд нэлээд онгоц, цэргийн амь нас эрсдсэн ч буцаж чадсан байж болох юм гэсэн таамаглал Японы судлаачдад байдаг.

Саяхан монголын “Маш нууц” сонинд далайн түүх судлагч нэгэн хүний өгүүлэл гарчээ. Тэрээр Монголын флотын үлдэгдлийг олохоор 3 зун ажилласан гээд 1274 онд живсэн гэгдэх онгоцууд 200 ба түүнээс дээш вэссэльд /далайн гүнийг хэмжих нэгж/ байсангүй. Харин Такашимагийн зүүн эргийн орчимд онгоцны үлдэгдэл нэлээд тохиолддог тухай өгүүлжээ. Энэ үед Монголчууд Азид бүрэн ноёрхож, дайснаа дараалан доройтуулж байсан учраас Японыг эзлэх нь тийм ч хэцүү зүйл байгаагүй. Харин гол дайсан болж байсан Нансо улсыг доройтуулахад Цушимаг довтлох тактикийн чанартай алхам зайлшгүй хийх шаардлага гарсан байна. Харин энэ анхдугаар довтолгооны тухай нууц мэдээллийг Нансогийн хэдэн лам хуврагууд бурхан шашны хэргээр явaa гэдэг нэрийн дор жанч нөмрөн Жипан /Япон/-д очиж мэдээлсэн байж магадгүй гэж судлагчид тэмдэглэсэн нь оргүй ч зүйл биш бололтой.

### **Хубилай хааны далайн цэргийн хоёрдугаар довтолгоон ба бусдад найдсан дипломат бодлогын сүйрэл**

1274 оны довтолгоон Кюшу аймгийн Хаката гэдэг хотын орчим болж өнгөрсөн явдлын ул мөр өдгөө Монголчууд Японд довтолсон нь /Ген ко кинен нохи/ гэрэлт хөшөө болой. Монголын эзэнт гүрний удирдагчид Японы асуудлыг анхаарлынхаа гадна нэг ч өдөр орхиогүй ажээ. Нансо улсыг нэгтгэсний дараа Японыг хашраах ээлжээ хүлээж байв. Тэрхүү үйл явдлын өмнө Чингис хааны үеэс Монголын төрийн бодлогын үндэс-элчин дипломатын үйл ажиллагаа ач холбогдоо алдаагүй байв. 1281 оны хоёр дахь довтолгооны өмнө олон цэрэг эрсийн амь насыг талаар үрэхгүйн төлөө Монголын эзэнт гүрэн өөрөөс шалтгаалах бүхнийг хийснийг түүхийн баримтууд гэрчлэн хоцорчээ. Үүний тул хэд хэдэн элчийн үйл ажиллагааг дурдах ёстой болно. Япон, Нансогийн харилцааны гол төв Цушима аралд тактикийн довтолгоо хийсний дараа Юаны 6 хүний бүрэлдэхүүнтэй элчийг Японд илгээсэн байна. Үүнд: Тусачу 34 настай Юан хүн буюу монгол үндэстэн, Хэ Вей Жу 38 настай хятад туслах, Санду Людин 32 настай Ислам туслах, Жу Сан 32 настай Гуулин туслах, Ка 32 настай Шүнви үндэстэн туслах, Жоса /онгоцны ахмад/ нар багтжээ. Илгээлтийн гол утга нь: Дахин энгийн цэрэг, ард иргэний амь биеийг хөнөөх дайнд хүрэлгүй бууж өг. Үүнийг сайтар тунгаатугай гэсэн байж. Эдгээр элч нарыг Хубилай хааны илгээлтийг хүргэж Японд очих үед Камеяама хаанчилж байсан боловч нэгэнт Юаны цэргийн болзошгүй аюул заналын өмнөөс сөрөн зогсох зориг, хүч дутсан учраас бүх эрх мэдлийг нь цэргийнхэн буюу Шёогин булаан авч өөрийн засгийн газрыг Камакурад эмхлэн байгуулж, цэргийн хүч хуримтлуулсаар байжээ. Цаг хожих үүднээс уттал хүлээлгэсний эцэст 5 элчийг Камакурагийн ойролцоо Тацуноокучид цаазаар авч харин хөлгийн ахмад Жоса үл мэдэгдэх байдлаар сураггүй алга болжээ.

Үүнээс хойш нэг хэсэгтээ Япон руу чиглэсэн цэрэг дайны бодлого намжуу байдалтай болсон нь санамсаргүй хэрэг байсангүй, 1274 оны Япон руу хийсэн довтолгооноор Япон, Нансогийн дотно харилцаа тасалдаж, Монголчуудад гол

дайсан болоод асан эх газрын Нансо улсыг эрхшээн авах таатай нөхцөл бүрэлдэн 1276 онд Нансод довтолж, 1279 онд өөрийн ноёрхлыг бүрэн тогтоож чадав.

Үүний дараагаар Япон руу чиглэсэн бодлогоо дахин сэргээжээ. 1279 онд Нансогийн цэргийн жанжин байсан Хамбүко, түүний туслах Шихүку, Ланчү, Чинко нарыг Япон улс руу элчээр явуулжээ. Нансогийн цэргийн жанжин Хамбүко Япон улстай их шадар холбоотой байсан цэргийн эрхтэн байв. Хубилай хаан үүнд нь их ач холбогдол өгч ихээхэн найдвар тавьж байлаа. Гэвч хамт очсон 3 элчийг Хакатад цаазалж, харин эртний түнш Хамбүког өршөөн буцаасан аж. Энэ мэдээ Хубилай хаанд хүрч ирснээр “тэснэ тэснэ” гэхэд үүнээс илүү яж тэсэх вэ гэдэг шиг Япон улсыг цэргийн хүчээр зайлшгүй номхотгох нь зүйтэй гэсэн бодлыг лавшуулж өгчээ. Уг нь тэдгээр элчид ихээхэн найдвар тавьж Солонгост цэргийн усан онгоц барих, зэр зэвсэг бэлтгэх зэрэг цэрэг дайны бэлтгэл ажлаа түр зогсоон хүлээнэж байж. Нөгөө талаар Солонгосын дотоодод иргэний шинжтэй жижиг дайн самуун ч дэгдээд байсан нь өөр нэг шалтгаан нь байлаа.

Гэтэл 1280 онд Япон улс Солонгосын Жипо гэдэг жижиг хойг руу гэнэт довтлон оржээ. Япончууд хэдийнээс Солонгост довтлохыг хүсэн хүлээж байсан бололтой. Үүний гол шалтаг шалтгаан нь сонирхолтой юм. Солонгос улс удаа дараа Юань гурний дуулгавартай зарц, гар хөл нь болж, элч зардас илгээн ятган ухуулж бас тулган шаардаж байсанд Японы цэргийн эрхтнүүд далдуур бухимдан хорсож байсан нь ойлгомжтой. Үүний дараахан Хубилай хаан цэрэг дайны бэлтгэл ханалаа гэж үзэн 1281 оны 1 сарын 1-нд хуралдай зарлан Алахан, Хамбүко, Кинто, Косаку нарыг Японд довтлох цэргийн жанжидаар томилсон зарлиг гаргасан байна. Ингээд 2 сарын 20-нд Алаханаар удирдуулсан Их Юань гурний олон үндэстнээс бүрдсэн цэргийг далайд гаргажээ. Эдгээр цэрэг олон үндэстний цэрэг байсан учраас хаан сэтгэл багагүй зовж ...эв найртай, нэгэн захиргаанд яв, Японд хүрээд энгийн ард иргэн, тариачдыг ихээр алж хэлмэгдүүлж болохгүй гэж хатуу цаазлажээ.

Харамсалтай энэ үед Япончууд дайсныхаа арга мэхийг мэддэг төдийгүй тэдний эсрэг шинэ, өвөрмөц хамгаалалтын тактик боловсруулсан байлаа. Тоурагийн 40000 цэрэг 5 сарын 3-нд 900 хөлөг онгоцтойгоор Солонгосын боомт хот Каппогоос Япон руу хөдөлж мөн сарын 21-нд Цушимагийн Сагаүрад цөмрөн орж өзлээд, 26-нд Ики рүү довтолгооноо ургэжлүүлсэн аж. Тэндээсээ Ноко, Шика хоёр арлын дунд Япон цэрэгтэй далайд тулгарч багагүй хохирол амсаж. Энэ үед Кунань цэрэг хараахан ирээгүй байсан учраас Тора цэрэг хүчин мөхөсдөх байдалтай болж Хаката руу шилжихээр шийдвэрлээд байтал халуун дулааны улирал тул олон хүн амь үрэгдсэнээс халдварт өвчин дэлгэрч арга буюу Эки рүү эргэн байршжээ. Мөн сарын 18-нд Кунань цэрэг Хятадын өмнөд хэсэг дэх Кейгин гэдэг боомтоос Япон руу хөдөлж, мөн сарын 29-нд Кунань цэргийн түрүүч Экид хүрэлцэн ирж Тоура цэрэгтэй нэгджээ. Цэргийн жанжинаар Алахан ирсэн боловч удалгүй далайн өвчнөөр өвдөж, цэргийн удирдлагыг Атахай /япон дуудлагаар Адурай/ авч тулалдааныг удирдсан аж. Юаны их цэрэг Кунань, Тоура хэмээх хоёр үндсэн бүлэглэл болж байж. Кунань цэрэг нийтдээ 3500 хөлөг онгоцтой байсан гэж бичжээ. Үүний бүрэлдэхүүнд Өмнөд Су буюу өмнөд хятадын цэрэг дийлэнх нь байсан бөгөөд нийтдээ 100000 хүнтэй байв. Энэ цэрэг X-XI зууны үед Зүүн Азийн бүсэд маш хүчтэйд тооцогдож байв. Өмнөд Су улс /1127-1279 оны хооронд оршин байв/ Тайвань арлын ойрх одоогийн зүүн өмнөд хятадын эрэг хавийг хяналтдаа байлгаж байсан бол Хогсо /хойд/ Ся улсын /960-1279 он/ оршиж байгаад дараа нь тэдгээрийн оронд Нансо улс байгуулагдсан түүхтэй. Нансо далайн эрэг хавь газар ба төв хятадын нэлээд хэсгийг хамарч, Япон улстай бүх талаар ойр дотно харилцаатай хүчирхэг улс байжээ. Монголчууд 1276-79 онд Нансо улсыг доройтуулан Их Юань гурний эрхшээл ноёрхлыг тогтоосон байна.

Кунань цэрэг Япон улс руу цөмрөхдөө хоёр чиглэлээр орсон бөгөөд нэг хэсэг нь Такашима арлаар довтолж, нөгөө хэсэг нь Цушимад буугаад тэндээсээ Эки рүү довтолсон.

Тоурагийн цэргийн бүрэлдэхүүнд Монгол, Хятадын 15000, Солонгосын 10000 цэрэг довтолгоонд оролцсон баримт байдаг.

1281 оны довтолгооны ерөнхий маршрутыг үзэхэд анх Юань цэрэг Кюшү болон Эки арлын дунд байх Такашима /шонхорын арал/ арлыг түшиц газар болгосон. Дараа нь Экид хүрээд тэндээсээ далайгаар явж Такашима арлыг эзэлсэн байна. Тэндээсээ газраар Мацураг эзлэн Кунань, Тоурагийн хоёр замын цэрэг Хаката далайн боомтод нэвтэрсэн нь Японы түүхийн бүтээлүүдэд хэвлэгдсэн байлдааны зургаас харагддаг. Японы түүхийн баримтуудаас үзэхэд 1281 оны довтолгооноор Такашима арлын дэргэдэх тулаанд 10000 орчим цэрэг, Шикано Шима аралд 8,9 мянган цэрэг үрэгдсэн тоо байна. Өнөөг хүртэл мөн л домогт далайн хар шуурга ниргэсэн гэж нотлон ярьж байдаг ч тэд буцаад явсан юмуу эсвэл мөнөөх Камикизе-д дахин залгиулсан эсэх нь Японы судлагчдын анхаарлыг өнөөг хүртэл татсаар байгаа сонирхолтой судлагдахуун байсаар аж.

Их Юань гүрний нэгдсэн цэрэг Япон улс руу /далайд/ тулалдсан түүхийн орооцолдоон, түүний учир шалтгаан, угтвар нөхцөл нь ийм аж. Энэхүү өгүүллийг бичихэд “Монголын довтолгоон ба 700 жил Нихон ТВ Токио 1981, 2001” ном болон Япон түүхийн судалгаа зэрэг ном ашигласан ба далайн хөлөг онгоцны түүх судлагч Музай Торао, түүхч Мацууга Итоши, Урлагийн түүхч Оз Коучи, Кюшүгийн тулааны түүхт газрыг судлагч Кога Нэнко, далайн гүнийг цахилгаан соронзон орны тусламжтай тандан судлагч Танака Исүказу гуай нарын бүтээлээс ашигласан болно. Энд хэрэглэсэн нэлээд нэрүүдийг япон нэр, дуудлагаар нь бичсэнийг хэлэхийн ялдамд хэл ул муугаас буруу зөрүү ойлгож, алдаж эндсэн зүйл буй аваас өршөөн хэлтрүүлмүй.

### Abstract

The author describes political agenda, practical reasons and relevance, and diplomatic policy beyond two large-scale invasions by Khubilai Khan towards Japanese islands within Pacific region. The primary goal of this warfare was to perform on-land tactic army ‘training’, not to invade Japan, as documents suggest.

### Ашигласан ном зохиол

1. “Монголын довтолгоон ба 700 жил Нихон ТВ Токио 1981, 2001”
2. “Япон түүхийн судалгаа”